БАТЛАВ: ЗАХИАЛАГЧ
СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА
М.ИДЭРБАТ

БАТЛАВ: ГҮЙЦЭТГЭГЧ
"РИЧВЕЛЛ ИНЖЕНЕРИНГ" ХХК-ИЙН ЗАХИРАЛ
Д.ГАНТӨМӨР

УЛААНБААТАР ХОТ
RICHWELL ENGINEERING LLC
РИЧВЕЛЛ ИНЖЕНЕРИНГ ХХК

ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ГЭРЭЭ

2021-06-24 № ЗТ2021/09 Баруун-Урт хот

Нэг. Гэрээний үндсэн нөхцөл

1.1 Монгол улсын Иргэний хууль, Барилгын тухай хууль, Барилгын зураг төсөл боловсруулах, зөвшөөрөлцөх, батлах дүрэм /БНбД 11-01-08/ болон бусад хууль тогтоомжийг үндэслэн нэг талаас Сүхбаатар аймгийн Засаг даргын Тамгын газар, түүнийг төлөөлөн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс /цаашид "захиалагч" гэх/, нөгөө талаас барилгын зураг төслийн "Ричвелл инженеринг" ХХК /цаашид "гүйцэтгэгч" гэх/ нарын хооронд **Сүхбаатар аймгийн Уулбаян суманд баригдахаар боловсруулагдсан 188/2013 магадлалын дугаартай, MSL-18-26 шифртэй 75 ортой дотуур байрны барилгын зураг төслийг техникийн нөхцөл, газрын өөрчлөлт байршлаас хамааран Сүхбаатар аймгийн Халзан сумын төвд баригдах дотуур байрны барилгын холболтын зураг төсөл боловсруулж, төсөвт өртгийн тооцоог хийх** харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, эдлэх эрхүүдийг эцэслэн тохирч хэрэгжүүлэхэд энэхүү гэрээний зорилго оршино.

Хоёр. Ерөнхий зүйл

2.1 Барилгын иж бүрэн зураг төслийн ажил нь холбогдох даалгаварууд ирсэн өдрөөс хойш хуанлийн 45 хоногт хийж гүйцэтгэхээр энэхүү гэрээг байгуулав. Дээрхи хугацаанд орон нутагтай зөвшилцөх хугацаа орсон болно. (холбогдох зөвшөөрлүүд болон магадлалын хугацаа ороогүй)

2.2 Энэхүү гэрээ нь хоёр тал харилцан тохиролцож тамга дарж баталгаажуулсан өдрөөс хүчин төгөлдөр болно.

2.3 Барилгын зураг төсөл боловсруулах ажлын үнийг "Зураг төслийн ажлын жишиг үнэ" БД 81-16-12-ыг үндэслэн **26 000 000 /Хорин зургаан сая/** төгрөг байхаар тохиролцов. (хуучин үнэлгээгээр тооцсон болно.)

2.4 Дээрхи үнэд НӨАТ, инженер-геологи, магадлалын зардал болон бусад бүх зардал орсон болно.

Гурав. Захиалагчийн эрх, үүрэг

3.1 Зураг төсөл боловсруулах явцад өөрсдийн саналаар нэмэлт өөрчлөлт оруулах буюу гэрээний хугацааг өөрчлөх, гэрээг цуцлах тохиолдолд гүйцэтгэгчтэй хамтран гэрээг дүгнэж, хийгдсэн ажлын хэмжээнд зураг төслийн үнэлгээгээр үнэлэн гүйцэтгэгч талд холбогдох төлбөрийг төлнө.

3.2 Захиалагч нь газар эзэмших ашиглах эрхийн гэрчилгээ, газрын кадастрын зураг, зураг төсөл боловсруулах даалгавар, архитектур төлөвлөлтийн даалгавар, цэвэр бохир ус, холбоо, цахилгаан, дулаан хангамжийн техникийн нөхцлүүд зэрэг холбогдох материалуудыг ажил эхэлхээс өмнө бүрдүүлж гүйцэтгэгчид өгнө.

3.3 Захиалагч нь зураг төсөл боловсруулах ажлын явцыг хянах эрхтэй.
3.4 Захиалагч нь зураг төслийг гэрээнд заасан хугацаанд дуусгахыг шаардах эрхтэй.
3.5 Захиалагч нь гүйцэтгэсэн ажлыг хүлээн авч тохиролцсон хөлсийг төлөх, талуудын хооронд энэхүү гэрээтэй холбоотой үүсэх харилцааг зохицуулна.
3.6 Барилгын талбайн инженер-геологийн дүгнэлтийг магадлалаар баталгаажуулж гүйцэтгэгчид хүлээлгэн өгнө.

Дөрөв. Гүйцэтгэгчийн эрх, үүрэг

4.1 Гүйцэтгэгч нь Халзан суманд баригдах 75 ортой дотуур байрны барилгын зураг төсөл, гадна иж бүрэн шугам сүлжээний зураг төсөл, төсөвт өртөгийн тооцоо /цаашид "ажил" гэх/-ыг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандартын дагуу хийж гүйцэтгэнэ.
4.2 Гүйцэтгэгч нь норм, дүрэм, стандартад нийцсэн зураг төслийг боловсруулж хүлээлгэн өгөх үүрэгтэй.
4.3 Зураг төслийг хийх, хэрэгжүүлэх явцад алдаа дутагдал илэрвэл уг асуудлыг шуурхай шийдвэрлэж өгөхийн зэрэгцээ зураг төсөлтэй холбогдох хариуцлагыг хүлээнэ.
4.4 Гүйцэтгэгч нь гэрээгээр хүлээсэн үүргүүдээ биелүүлсэн нөхцөлд гэрээт ажлын санхүүжилтийг хугацаандаа хийхийг шаардах эрхтэй.
4.5 Барилгын ажилд хийх зураг төслийн зохиогчийн хяналтыг тусгайлсан гэрээгээр гүйцэтгэнэ.
4.6 Гэрээний үнэнд багтсан Барилгын талбайн инженер-геологийн дүгнэлтийн зардлыг төлөх үүрэг хүлээнэ.

Тав. Төлбөр, тооцоо

5.1 Гэрээ батлагдахад эцсийн дүн болох **26 000 000 /Хорин зургаан сая/** төгрөгийг 2 талд харилцан тохиролцов.
5.2 Дээрх төлбөр тооцоонд хамрагдаж хийгдэх ажлын цар хүрээ:
   5.2.1 Барилга архитектур
   5.2.2 Барилга бүтээц
   5.2.3 Гадна, дотор Цэвэр бохир ус, усан хангамж ариутгах татуурга
   5.2.4 Гадна, дотор Цахилгаан
   5.2.5 Гадна, дотор Холбоо дохиолол
   5.2.6 Гадна, дотор Халаалт салхивч
   5.2.7 Төсөвт өртгийн тооцоо
   5.2.8 Барилгын талбайн инженер-геологийн судалгаа (захиалагч өгнө)

5.3 Гэрээний 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төлбөр болон 2018 оны 3-р сарын 29-ний өдөр захиалагчтай байгуулсан 2018/06 дугаартай гэрээний 4 дүгээр зүйлийн 4.1-д заасан төлбөрүүдийг 2022 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтад батлагдсан тохиолдолд батлагдсан эх үүсвэрээс зураг төсөл хүлээлгэн өгсөн актыг үндэслэн 100 хувь санхүүжүүлнэ.

Зургаа. Харилцан хүлээх үүрэг

6.1 Гүйцэтгэгч нь гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаанд нь гүйцэтгэж чадаагүй бол хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.03%-ийн торгууль хүлээнэ. Торгуулийн дүн нийт үнийн дүнгийн 30%-иас хэтрэхгүй байна.
6.2 Зураг төслийн гэрээний хугацаа захиалагчийн зүгээс бүрдүүлэх материал, хяналтын болон зөвшөөрөл олгох байгууллагуудаас шалтгаалсан хугацаа хоцролтыг гэрээний хугацаа хоцорсонд тооцохгүй болно.

6.3 Захиалагч гүйцэтгэгчид төлбөр тооцоогоо хийхгүй бол мөн хоног тутам төлөгдөөгүй үнийн дүнгийн 0.03%-ийн торгууль хүлээнэ.

6.4 Талууд гэрээний биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол шүүхэд нэхэмжлэл гаргаж шийдүүлнэ.

6.5 Гэрээг 3% үйлдэж захиалагч, гүйцэтгэгч тус бүр нэг нэг хувийг хадгална.

ГЭРЭЭТЭЙ ТАНИЛЦАЖ, ХЯНАСАН:

Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга Х.Энхцэцэг

Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Д.Ариунжаргал

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Захиалагчийг төлөөлж:

Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Ж.Батсуурь

Санхүү төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн Б.Мөнхтуяа

Гүйцэтгэгчийг төлөөлж:

"Ричвелл инженеринг" ХХК-ийн Ерөнхий инженер Н.Мөнхчулуун

Гэрээний мэргэжилтэн Д.Сумъяа

Банк: Голомт банк
Данс дугаар: 3455136514
РД: 5600383
Утас, факс: 11-311425

Хаяг: Улаанбаатар хот,Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сити тауэр, 1103 тоот

Гэрээний хавсралт №1

Сүхбаатар аймгийн Халзан сумын нутаг дэвсгэрт баригдах 75 ортой дотуур байрны барилгын зураг төсөл боловсруулах ажлын зургийн үе шат,

№	Үе шат	Хугацаа
1	2	3
2	Гэрээ байгуулах, Барилгын эх загвар зураг боловсруулах	2021-07-09
3	Ажлын зураг төслийг боловсруулж дуусгах, хүлээлгэн өгөх	2021-08-09
4	Зураг төслийг Улсын экспертизийн албаар баталгаажуулан захиалагчид хүлээлгэн өгөх	2021-08-30
	Нийт	

Тайлбар: 2022 оны улсын төсөвт хөрөнгө батлагдсан тохиолдолд 100 хувь санхүүжилтийг олгоно.

Захиалагчийг төлөөлж:
Сүхбаатар аймгийн ЗДТГ-ын
ХОХБТХ-ийн ахлах мэргэжилтэн
Ж.Батсуурь

Гүйцэтгэгчийг төлөөлж:
"Ричвелл инженеринг" ХХК-ийн
Ерөнхий инженер
Н.Мөнхчулуун

БАТЛАВ:
СҮХБААТАР АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА

.....
З. ЭНХТӨР

БАТЛАВ:
РИЧВЕЛЛ ИНЖЕНЕРИНГ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

.....
Д. ГАНТӨМӨР

ГЭРЭЭ No 2018/06

Ажлын нэр: Сүхбаатар аймгийн сумын Уулбаян сумын 75 хүүхдийн ортой дотуур байрны барилгын зураг төсөл боловсруулах

2018 оны 03-р сарын 29 Баруун-Урт хот

Нэг талаас Сүхбаатар аймгмийн Засаг даргын Тамгын газар /цаашид Захиалагч гэх/, нөгөө талаас Ричвелл Инженеринг ХХК /цаашид Захиалагч гэх/ нар (хамтад нь Талуууд гэх) дараах нөхцлөөр энэхүү гэрээг 2018 оны 03-р сарын 29-ий өдөр байгуулав

1. Гэрээний үндэслэл

Монгол улсын Барилгын тухай хууль, 2018 оны төсвийн тухай хууль, Засгийн газрын 2018 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн 34-р тогтоолын 1.3-р заалтыг үндэслэн болон бусад хууль тогтоомжийн дагуу "Сүхбаатар аймгийн сумын Уулбаян сумын 75 хүүхдийн ортой дотуур байрны барилгын зураг төсөл боловсруулах" ажилтай холбогдон Захиалагч, Гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг хариуцлага, ажлыг гүйцэтгэх хугацаа зураг төслийн ажлын үнийг тогтоох, үнийг төлөхөд энэхүү гэрээний зорилго оршино.

2. Ажил гүйцэтгэх хугацаа

   2.1. Гүйцэтгэгч нь энэхүү гэрээнд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн ажилдаа орж (эхлэх хугацаа 2018 оны 03-р сарын 29) 60 хоногт ажлыг гүйцэтгэнэ

3. Үйлчилгээ

   3.1. Захиалагч барилгын зураг төсөл боловсруулах даалгаврыг болон төсвийн төлөвлөгөөг баталж гүйцэтгэгчид хүлээлгэн өгнө.
   Хавсралт
   - Ажлын даалгавар (001/ЗД-2018)
   - Төсвийн төлөвлөгөө

   3.2. Гүйцэтгэгчид барилгын зураг төслийг батлагдсан зургийн даалгаврын дагуу архитектур төлөвлөлт, инженерийн болон техник технологийн шийдлийг шинжлэх ухаан техникийн дэвшилтэй уялдуулан өөрийн орны нөхцөлд тохируулж техникийн нөхцлийн дагуу боловсруулахын хамт Монгол Улсад мөрдөгдөж байгаа барилгын норм, журам, стандартыг баримтлан хийж гүйцэтгэнэ

   3.3. Зураг төслийг зургийн экспертизээр баталгаажуулах, угсралтын ажлыг гүйцэтгэх явцад алдаа дутагдал илэрвэл Гүйцэтгэгч түүнийг үнэ төлбөргүй шуурхай шийдвэрлэж өгнө.

7.2. Гүйцэтгэгч ажил дуусгах хугацааг (гэрээний 3.1-д заасан) хожимдуулсан тохиолдолд хугацаа хожимдуулсан хоног тутамд гэрээний гүйцэтгээгүй үнийн дүнгийн 0.02%-иар алдангийг Захиалагчид Гүйцэтгэгчид төлөх мөнгийг төлөөгүй тохиолдолд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн хугацаа хожимдуулсан хоног тутамд 0.02% -иар алдангийг Захиалагч гүйцэтгэгчид төлнө.

7.3. Энэ гэрээнээс үүсэх маргаантай асуудлыг талууд хэлэлцээр хийх замаар шийдвэрлэнэ. Хэрэв талууд тохирлцоонд хүрч чадахгүй бол шүүхээр шийдвэрлүүлнэ

8. Гэрээний үйлчлэх хугацаа, гэрээг өөрчлөх

8.1. Энэ гэрээ нь талууд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болж, талууд гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн гүйцэтгэж дуусах хүртэл үйлчилнэ

8.2. Талууд харилцан зөвшилцсөний үндсэн дээр энэ гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах, гэрээг сунгаж болно

9. Бусад зүйл

9.1. Энэхүү гэрээг хууль зүйн хувьд адил хүчинтэй хоёр хувь үйлдэж талууд тус бүрт нэг хувь хадгалагдана.

ЗАХИАЛАГЧ
Сүхбаатар аймгийн
ЗДТГ-ын ХОХБТХэлтсийн даргын түр орлон гүйцэтгэгч

У.Амарзаяа

ГХБХБГ-ын дарга

Х.Хишигбадрах

ГХБХБГ-ын барилга, шугам сүлжээ хариуцсан мэргэжилтэн

С.Наранцацралт

Хаяг: Сүхбаатар аймгийн Засаг Даргын Тамгын Газрын Байр
Утас: 70518090

Гүйцэтгэч
Ричвелл Инженеринг ХХК
Ерөнхий инженер

Н. Мөнхчулуун

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 8-р хороо, Сүхбаатарын талбай-5, СитиТауэр 1103
Утас:11311425, 88008012, 88111879

Зураг төсөл хүлээлцсэн акт

2018-08-01 Баруун урт

- Захиалагч: Сүхбаатар аймгийн ЗДТГ
- Гүйцэтгэгч : "Ричвелл инженеринг" ХХК
- Объектын нэр: 75 хүүхдийн дотуур байрны ажлын зураг төсөл
- Байрлал: Сүхбаатар аймаг, Уул баян сум, 1-р баг
- Шифр: RW-1802
- Хүлээлцсэн огноо: 2018-08-01
- Захиалагчийн төлөөлөл: Д.Наранцацралт
- Гүйцэтгэгчийн төлөөлөл: Д.Содхүү

Зураг төслийг хүлээн авсан байгууллага Сүхбаатар аймгийн ЗДТГ-т дараах зураг төслийг шалган үзэж энэхүү актыг үйлдэв.

Д/д	Зургийн нэр	Хуудасны тоо	Хувь	Дүгнэлт хавсралт
1	Уулбаян сумын 75 хүүхдийн дотуур байрны загвар зураг /А4/	Хуудас-10	Эх хувь-1 Хуулбар хувь-3	
2	Уулбаян сумын 75 хүүхдийн дотуур байрны загвар зураг /А3/	Хуудас-10	Эх хувь-1 Хуулбар хувь-3	
3	Уулбаян сумын 75 хүүхдийн дотуур байрны барилгын зураг төсөл / барилга бүтээц, ерөнхий төлөвлөгөө, барилга архитектур, халаалт агаар сэлгэлт, цэвэр бохир ус, гадна дулаан, ус хангамж ариутгах татуурга, дотор цахилгаан, гадна цахилгаан, дотор холбоо, гадна холбоо Уулбаян сумын 75 хүүхдийн дотуур байрны зуухны барилгын зураг төсөл / барилга бүтээц, барилга архитектур, халаалт агаар сэлгэлт, дулаан механик, дотор цахилгаан,	Хуудас-191	Эх хувь-1 Хуулбар хувь-3	
4	Уулбаян сумын 75 хүүхдийн дотуур байрны магадлалын ерөнхий дүгнэлт, хавсралт, зургийн гэрээ, магадлалын гэрээ, зураг төсөл боловсруулах даалгавар, архитектур төлөвлөлтийн даалгавар	Хуудас-48	Эх хувь-1 Хуулбар хувь-3	
5	Уулбаян сумын 75 хүүхдийн дотуур байрны барилгын талбайн инженер геологи	Хуудас-18	Эх хувь-1 Хуулбар хувь-3	
6	Уулбаян сумын 75 хүүхдийн дотуур байрны барилгын барилга угсралтын ажлын төсөв	Хуудас-166	Эх хувь-1 Хуулбар хувь-3	
6	Уулбаян сумын 75 хүүхдийн дотуур байрны иж бүрдэл PDF файл		2 хувь CD	

Хүлээн авсан:

Сүхбаатар аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ийн мэргэжилтэн ...../Д.Наранцацралт/

Гар утас: 99043068

Хүлээлгэн өгсөн:

"Ричвелл инженеринг" ХХК-ны инженер...../Д.Содхүү/

Гар утас: 88129515

0002033

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

Дугаар 8718-2140/17

"Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай" Монгол Улсын хуулийг үндэслэн Улаанбаатар аймаг/нийслэлийн Хан-Уул сум/дүүргийн "Гичвелл инженеринг" ХХК-д

9111354005 /улсын бүртгэлийн дугаар/ 5600385 /регистрийн дугаар/

Зураг төсөл I.2.2, I.2.4, I.2.5, I.2.6, I.3.1, I.3.2, I.3.4, I.3.5, I.3.6 заалтын дагуу ажил, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг 2017 оны 12 -р сарын 17 -ны өдрөөс 4 жилийн хугацаатай олгов.

Тусгай зөвшөөрөл нь хавсралт болон гэрээний хамт хүчинтэй.

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД Х.БАДЕЛХАН

2017 оны 12 -р сарын 14 өдөр

Улаанбаатар хот

Ажил үйлчилгээний төрөл:

I.2.2 I-IV давхар барилга байгууламжийн барилга архит
телевлогос, тохижилт, өнгөржилт, барилга бүтээц
Барилгын зохион байгуулалтын зураг тесел /БЗБГ,
Барилга байгууламжийн тоног төхөөрөмж, инженер
бункер, силос, цамхаг, яндан, антенна гэх мэт/-
зохион байгуулалтын зураг тесел /БЗБТ, АГТ, ҮЗБ

I.2.4 Дотоо усан хангамж, ариутгах татуурга, халаалт,
хөргөлтийн систем, гадна салбар шугам сүлжээ, т
барилга байгууламжийн технологийн зураг тесел

I.2.5 Дотоо гэрэлтүүлэг, цахилгаан хангамж, гадна сал
холбогдох барилга байгууламжийн технологийн зур
Дотоо радио холбоо, галын болон бусад дохиоллын
менежеллийн байгууламжийн зураг тесел, хамгаалал
холбогдох барилга байгууламжийн технологи, комп
дотоод сүлжээ, гадна салбар шугам сүлжээний зур
олон нийт, үйлдвэрийн барилгын болон тоног техх
хөргөгсөл /ХЦ/, автоматикийн зураг тесел

I.2.6 Техник, эдийн засгийн үндэслэл, барилгын тесел

I.3.1 Дулаалгын шугам гол сүлжээ, түүнтэй холбогдох ба
технологийн ажлын зураг

I.3.2 Усан хангамж, ариутгах татуургын гол шугам сүлж
барилга, байгууламжийн технологийн ажлын зураг

I.3.3 Усны барилга байгууламжийн зураг тесел

I.3.3 Эрчим хүчний эх үүсвэрийн технологийн зураг тес

I.3.4 Цахилгаан дамжуулах гол шугам, түүнтэй холбогдо
технологийн ажлын зураг

Нэмэлт өөрчлөлт: /2

МОНГОЛ УЛС
ЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

2012.05.14 № 000079808 9011354005

/ Бүртгэсэн он,сар,өдөр / / Улсын бүртгэлийн дугаар /

5600383

/ Регистрийн дугаар /

Ричвелл инженеринг Хязгаарлагдмал хариуцлагатай компани

/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Дүрэм

/ Үүсгэн байгуулах баримт бичиг /

Шийдвэр 01 2012.04.30

/ шийдвэрийн нэр / / дугаар / / он, сар, өдөр /

4610 Гадаад худалдаа

/ код / / Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

20210401

он сар ... өдөр бүртгэлийн № 1224

Нийслэлийн Сүхбаатар дүүргийн

тойргийн нотариатч Ц.Одонтуяагийн

энэ хуулбар үнэн зөвийг гэрчлэв.

Үйлчлүүлэгчийн хүсэлтээр хуулбар

Нотариатч .....

/ код / / Туслах эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

Хугацаагүй 1 3,000.00

/ хугацаа / / гишүүдийн тоо / / өөрийн хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр /

Улаанбаатар, Хан-Уул, 15-р хороо, рапид харш, 23, 48 тоот, Утас1: 311425, Утас2: , Факс:

/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг /

Улсын бүртгэлийн ерөнхий газрын Бүртгэлийн газар

/ бүртгэсэн байгууллагын нэр /

Гэрчилгээ дахин олгосон 2014 он 4 сар 29 өдөр

Харилцах дансны бүртгэл

Харилцагч банкны нэр	Дансны төрөл	Дансны дугаар	Бүртгэсэн ажилтан тэмдэг
Худалдаа хөгжлийн банк	*Валютын*	*499201257*	*Ш.Цэнгэл*
Худалдаа хөгжлийн банк	*Валютын*	*499201256*	*Ш.Цэнгэл*
Худалдаа хөгжлийн банк	*Төгрөгийн*	*499201255*	*Ш.Цэнгэл*

Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

Д/д	Нэмэлт өөрчлөлтийн агуулга	Бүртгэсэн	
		Огноо	Ажилтан тэмдэг
1	*Дайриймаа овогтой Гантөмөр-г Захирал-р томилсныг бүртгэв.*	*2014.04.29*	*Э.Эрдэнэбилэг*
2	*Дахин гэрчилгээ олгое.*	*2014.04.29*	*Э.Эрдэнэбилэг*
3	*Эцэгийн өмчлөгч 1 ирсэн бүртгэв.*	*2020.04.20*	*М.Монголжин*
4	*35109 Эрчим хүчний эх үүсвэрийн ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах 03.9.1. 03.9.4, 03.9.6, 03.9.9-заалтын дагуу үйл ажиллагаа эрхлэх /2018.10.09-2020.10.09/ үйл ажиллагаа шинээр бүртгэв.* *35106 Эрчим хүчний дэд станцын барилга угсралт 03.2.4, 03.3.2-заалтын дагуу үйл ажиллагаа эрхлэх /2018.05.09-2021.05.09/ үйл ажиллагаа шинээр бүртгэв.* *41000 Барилгын зураг төслийн 1.2.2, 1.2.4. 1.2.5. 1.2.6, 1.3.1. 1.3.2, 1.3.4. 1.3.5, 1.3.6. -заалтын дагуу үйл ажиллагаа эрхлэх /2022.12.17-2022.12.17/ үйл ажиллагаа шинээр бүртгэв.*	*2020.04.20*	*М.Монголжин*